



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/22/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням
Утас: 51-261665 Цахим хаяг: Sambuunyamya@audit.gov.mn
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: М.Ганбаатар
Утас: 261628 Цахим хаяг: ganbaatarm@audit.gov.mn
Аудитор: Я.Марал-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn

АГУУЛГА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	16
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа	16
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	18
3.4.1 Мөнгөн хөрөнгө	19
3.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	21
3.4.3 Авлага	21
3.4.4 Урьдчилгаа.....	22
3.4.5 Бараа материал.....	23
3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө	24
3.4.7 Үндсэн хөрөнгө	24
3.4.8 Өр төлбөр.....	26
3.4.9 Засгийн газрын хувь оролцоо	27
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	27
4.1 Ерөнхий зүйл	32
4.2 Материаллаг байдал	32
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	32
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	32
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	33
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	39
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	39
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	40
5.1 Харьяа байгууллагууд.....	40
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит	40
5.2.1 Аудитаар илэрсэн зөрчил	40
Албан шаардлага	40
Зөвлөмж	41
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	42

Товчилсон үгийн жагсаалт

ААОДБАӨЗ	Архангай аймгийн оюутны дотуур байрын ашиглалтын өмнөх захиргаа
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БС	Боловсролын сайд
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БСДХТ	Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө
БЯ	Боловсролын яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИДСХМТ	Их, дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв
МББ	Мэргэжлийн боловсролын байгууллага
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ШУТИСХПТК	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Политехникийн коллеж



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

**БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА**

2025. 04. 25 № 1609
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 409,590.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон 54,846.9 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 7, 15 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна. Тухайлбал:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон гэрээний үүрэг зөрчигдсөн нийт 168,119.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 42 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай, мөн тайлант онд гэрээнд заасан хугацаанд багтаан ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн нийт 11,274.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээний барилгын ажлын гэрээг дүгнээгүй, гэрээнд заасны дагуу алданги суутган тооцоогүй;
- Төсөв хүрэлцээгүй сургуулийн өмнөх боловсролын 1000 байгууллага, ерөнхий боловсролын 684 сургуульд санхүүжилтийг нөхөх зорилгоор журмын шаардлагыг

зөрчин батлагдсан төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулж, нийт 150,214.8 сая төгрөгийг шилжүүлсэн;

- Боловсролын зээлийн сангийн тэтгэлгээр 2,130.6 сая төгрөгийн санхүүжилт авсан 32 суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй, мөн 2,571.6 сая төгрөгийн зээл авсан 29 төгсөгчтэй холбоо тогтоогоогүй, зөрчлийг арилгаагүй.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбарын байгууллагууд хүүхдийн тоонд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлж байгаа бөгөөд улсын хэмжээнд салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн төлөв байдлыг дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын нийт 885 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 705 буюу 79.7 хувь нь төрийн өмчийн, 180 буюу 20.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна. Нийт 61,016 багш, ажилтан ажиллаж байгаагийн 37,770 нь буюу 61.9 хувь нь үндсэн багш байна. Ерөнхий боловсролын сургуулиудад нийт 797,905 сурагч суралцаж байгаагаас 379,647 нь бага анги (I–V), 273,943 нь дунд анги (VI–IX), 144,315 нь ахлах анги (X–XII)-д тус тус хамрагдаж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн нөхөн олгох хөтөлбөрт 1,197 бүлэгт 4,422 суралцагч суралцаж байна.
- Сургуулийн өмнөх боловсролын нийт 1,407 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 1,024 буюу 72.8 хувь нь төрийн өмчийн, 383 буюу 27.2 хувь нь хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна. Салбарын хэмжээнд 35,339 багш, ажилтан ажиллаж байгаагаас 9,945 нь буюу 28.1 хувь нь үндсэн багшийн орон тоонд багтдаг. Мөн 9,226 бүлэгт нийт 264,818 хүүхэд хамрагдан суралцаж байгаагийн 253,158 нь үндсэн сургалтад, 11,660 нь хувилбарт сургалтад хамрагдсан байна.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын нийт 69 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 41 буюу 59.4 хувь нь төрийн өмчийн, 28 буюу 40.6 хувь нь хувийн өмчийн байгууллага байна. Эдгээр байгууллагад 40,906 суралцагч мэргэжил, ур чадвар эзэмшин суралцаж байгаа бол салбарын хэмжээнд 3,878 багш, ажилтан ажиллаж байгаагаас 2,140 буюу 55.2 хувь нь үндсэн багш байна.

Мөн Дээд боловсролын нийт 65 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 16 нь төрийн өмчийн, 1 нь төрийн өмчийн оролцоотой, 45 нь хувийн хэвшлийн, 3 нь олон нийтийн /шашны/ байгууллага байна. Тайлант онд төрийн өмчийн 6 их сургуулийн эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн 45,801.5 сая төгрөгийн төрийн өмчийн тогтмол зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 583, 128 дугаар тогтоолын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон боловсролын салбарын байгууллагын 98 нэрийн, нийт 428,294.4 сая төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгө болон Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4 дэх заалтад тусгагдсан "Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох" зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 74 нэрийн, 30,631.6 сая төгрөгийн үнэлгээтэй ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулж, санхүүгийн бүртгэлд нэмж бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

"Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд хийсэн Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсанаар, боловсролын салбарт хэрэгжүүлж буй 16 зорилтын хүрээнд нийт 68 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс гүйцэтгэлийн түвшин 75.8 хувьтай гарсан бөгөөд эдгээрээс 25 нь үр дүнтэй, 29 нь тодорхой үр дүнд хүрсэн, 13 нь цаашид эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,344,646,516.0	3,120,172,475.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	422,186,480.0	589,085,189.9
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	144,465.8	58,225.8
33	АВЛАГА	321,038,303.4	347,712,416.2
34	УРЬДЧИЛГАА	59,584,196.8	174,325,947.4
35	БАРАА МАТЕРИАЛ	220,702,769.6	261,162,224.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,320,990,300.4	1,747,828,471.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,119,839,459.6	5,387,448,469.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,119,839,459.6	5,387,448,469.8
39200	Биет хөрөнгө	4,019,328,874.9	4,312,586,871.8
39300	Биет бус хөрөнгө	1,100,510,584.7	1,074,861,598.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,464,485,975.6	8,507,620,944.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	88,757,994.0	161,230,297.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	88,532,383.3	161,193,020.7
41300	Өглөг	39,983,470.9	98,396,579.2
41400	Урьдчилж орсон орлого	48,548,912.4	62,796,441.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	225,610.7	37,276.9
42200	Урт хугацаат зээл	225,610.7	37,276.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,375,727,981.6	8,346,390,642.2
51	Засгийн газрын хувь оролцоо	7,375,727,981.6	8,346,390,642.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,153,966,642.2	1,101,910,483.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	765,568,561.6	765,568,561.6
51200	Хуримтлагдсан үр дүн	4,247,144,732.6	5,306,504,349.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,048,045.2	1,172,407,251.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,464,485,975.6	8,507,620,944.8

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,488,083,436.5	5,016,336,236.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	312,941.4	99,906.9
110	Орлогын албан татвар	312,941.4	99,906.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	312,941.4	99,906.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,326,182,925.9	976,737,008.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,318,257,328.8	947,083,400.1
122	Тусламжийн орлого	7,925,597.0	29,653,608.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,161,587,569.3	4,039,499,321.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,218,291,746.5	3,934,732,999.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,218,291,746.5	3,934,561,608.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,900,623,158.1	3,490,475,526.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,730,489,775.9	2,368,149,466.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,735,881.7	291,696,943.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,845,430.9	42,099,218.9
2104	Хангамж, бараа материалын зардал	49,957,633.4	133,990,241.6
2105	Нормативт зардал	219,504,643.1	139,759,387.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,876,577.0	14,110,808.7
2107	Томилолт, зочны зардал	6,365,617.9	4,312,855.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,704,914.4	86,399,357.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	336,142,683.8	409,957,247.1
211	ХҮҮ	452,917.4	470,122.4
212	ТАТААС	6,474,748.9	75,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,310,740,922.2	443,540,959.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	171,391.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,269,791,690.0	1,081,603,236.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,130,570.3	1,321,240.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	266,401,952.7	151,044,457.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,013,520,307.6	931,880,020.3

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,373,923,999.2	-	6,373,923,999.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(12,059,768.5)	-	(12,059,768.5)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,361,864,230.7	-	6,361,864,230.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(765,807.3)	-	(765,807.3)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,080,250.6	-	1,080,250.6
7	Өмчид гарсан өөрчлөлт	29,000.0	-	29,000.0
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,013,520,307.6	-	1,013,520,307.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,375,727,981.6	-	7,375,727,981.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,144,801.7	-	44,144,801.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	7,419,872,783.3	-	7,419,872,783.3
17	Өмчид гарсан өөрчлөлт	(10,147,271.1)	-	(10,147,271.1)
19	Тайлант үеийн үр дүн	4,785,114.8	-	4,785,114.8
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	931,880,020.3	-	931,880,020.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,583,358,715.7	4,539,448,662.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	404,983,493.7	487,918,257.5
120	Нийтлэг татварын бус орлого	397,291,672.3	487,810,373.5
122	Тусламжийн орлого	7,090,027.4	107,884.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	601,794.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,178,375,222.0	4,051,530,404.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,996,473,788.0	3,671,732,466.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,996,473,788.0	3,671,732,466.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,662,605,829.5	3,166,385,967.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,726,236,400.6	2,365,112,113.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,452,324.2	293,998,242.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,466,277.3	41,607,963.3
2104	Хангамж, бараа материалын зардал	14,625,954.3	10,219,609.2
2105	Нормативт зардал	210,102,395.2	131,690,818.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,944,544.6	14,621,651.8
2107	Томилолт, зочны зардал	6,205,595.4	3,915,338.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,528,475.9	107,975,311.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,043,862.1	197,244,919.4
211	ХҮҮ	451,287.8	435,427.0
212	ТАТААС	6,474,748.9	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,326,941,921.8	504,911,072.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	586,884,927.7	867,716,195.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	423,099,411.6	684,005,293.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	423,099,411.6	684,005,293.7
2200	Дотоод эх үүсвэрээр	423,099,411.6	684,005,293.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(423,099,411.6)	(684,005,293.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(14,869,234.5)	(16,812,191.7)
14	Бусад эх үүсвэр	9,352,457.9	5,813,157.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	15,061,439.5	13,487,783.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	9,160,252.9	9,137,565.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	148,916,281.6	166,898,709.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	273,270,198.5	422,186,480.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	422,186,480.0	589,085,190.0

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,151,508,954,400.00	3,947,039,727,633.88	204,469,226,766.12	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,427,417,749,600.00	3,398,386,628,598.96	29,031,121,001.04	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,806,492,047,100.00	2,802,897,875,801.01	3,594,171,298.99	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,069,428,038,800.00	2,068,502,261,455.42	925,777,344.58	100.0
210101	Үндсэн цалин	1,343,162,017,800.00	1,347,930,431,388.87	(4,768,413,588.87)	100.4
210102	Нэмэгдэл	702,228,164,900.00	672,616,060,831.34	29,612,104,068.66	95.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,960,291,500.00	13,261,714,160.99	698,577,339.01	95.0
210104	Урамшуулал	10,077,564,600.00	34,566,053,426.16	(24,488,488,826.16)	343.0
210105	Гэрээт ажлын хөлс	-	128,001,648.06	(128,001,648.06)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	264,343,318,800.00	264,197,016,292.61	146,302,507.39	99.9
210201	Тэтгэврийн даатгал	179,910,076,200.00	179,685,721,680.23	224,354,519.77	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	21,108,705,600.00	21,169,055,859.22	(60,350,259.22)	100.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,554,353,000.00	10,575,806,792.89	(21,453,792.89)	100.2
210204	Ажилгүйдлийн даатгал	10,554,353,000.00	10,554,948,830.75	(595,830.75)	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	42,215,831,000.00	42,211,483,129.52	4,347,870.48	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,298,634,500.00	4,206,697,869.90	91,936,630.10	97.9
210301	Гэрэл, цахилгаан	476,040,400.00	484,668,286.61	(8,627,886.61)	101.8
210302	Түлш, халаалт	1,475,513,700.00	1,390,809,034.63	84,704,665.37	94.3
210303	Цэвэр, бохир ус	249,274,700.00	223,551,584.76	25,723,115.24	89.7
210304	Байрны түрээс	2,097,805,700.00	2,107,668,963.90	(9,863,263.90)	100.5
2104	Хангамж, бараа материалын зардал	816,939,500.00	793,620,610.27	23,318,889.73	97.1
210401	Бичиг хэрэг	145,989,700.00	177,969,156.00	(31,979,456.00)	121.9
210402	Тээвэр, шатахуун	287,003,900.00	232,941,936.00	54,061,964.00	81.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	166,706,200.00	163,896,446.97	2,809,753.03	98.3
210404	Ном, хэвлэл	43,127,400.00	42,454,670.00	672,730.00	98.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,813,100.00	18,643,460.00	6,169,640.00	75.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	149,299,200.00	157,714,941.30	(8,415,741.30)	105.6
2105	Нормативт зардал	121,200,349,000.00	121,199,343,703.00	1,005,297.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,617,400.00	5,609,938.00	1,007,462.00	84.8
210502	Хоол, хүнс	121,187,098,400.00	121,187,065,715.00	32,685.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,633,200.00	6,668,050.00	(34,850.00)	100.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	889,391,200.00	888,630,010.56	761,189.44	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	288,903,400.00	287,957,542.00	945,858.00	99.7
210602	Тавилга	46,080,800.00	46,073,475.00	7,325.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,401,500.00	2,394,630.00	6,870.00	99.7
210604	Урсгал засвар	552,005,500.00	552,204,363.56	(198,863.56)	100.0
2107	Томилолт, зочны зардал	139,185,200.00	132,690,230.00	6,494,970.00	95.3
210702	Дотоод албан томилолт	139,185,200.00	132,690,230.00	6,494,970.00	95.3

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,193,719,300.00	139,043,614,631.43	2,150,104,668.57	98.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,016,154,800.00	138,883,786,083.12	2,132,368,716.88	98.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	54,234,100.00	51,250,700.00	2,983,400.00	94.5
210803	Даатгалын үйлчилгээ	7,843,600.00	5,447,701.00	2,395,899.00	69.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,064,700.00	2,089,572.00	1,975,128.00	51.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,528,100.00	583,400.00	944,700.00	38.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	97,567,100.00	94,640,095.31	2,927,004.69	97.0
210807	Газрын төлбөр	5,223,400.00	5,218,920.00	4,480.00	99.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,103,500.00	598,160.00	6,505,340.00	8.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,182,470,800.00	203,934,000,997.82	248,469,802.18	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,291,531,000.00	200,048,985,211.64	242,545,788.36	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,890,939,800.00	3,885,015,786.18	5,924,013.82	99.8
212	ТАТААС	2,256,300,000.00	2,256,300,000.00	-	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,256,300,000.00	2,256,300,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	618,669,402,500.00	593,232,452,797.95	25,436,949,702.05	95.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	237,091,185,400.00	233,063,260,256.24	4,027,925,143.76	98.3
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	237,091,185,400.00	233,063,260,256.24	4,027,925,143.76	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	381,578,217,100.00	360,169,192,541.71	21,409,024,558.29	94.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,630,800.00	20,630,800.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	222,539,459,100.00	204,502,415,710.09	18,037,043,389.91	91.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,278,954,900.00	50,431,913,817.92	1,847,041,082.08	96.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	106,333,916,800.00	104,825,660,908.70	1,508,255,891.30	98.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	405,255,500.00	388,571,305.00	16,684,195.00	95.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	723,054,874,900.00	546,890,701,011.58	176,164,173,888.42	75.6
220001	Барилга байгууламж	655,576,960,500.00	484,355,546,654.78	171,221,413,845.22	73.9
221001	Их засвар	2,811,859,600.00	2,648,016,124.80	163,843,475.20	94.2
222001	Тоног төхөөрөмж	64,666,054,800.00	59,887,138,232.00	4,778,916,568.00	92.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,036,329,900.00	1,762,398,023.34	(726,068,123.34)	170.1
230001	Эргэж төлөгдөх зээл	1,036,329,900.00	1,762,398,023.34	(726,068,123.34)	170.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,151,508,954,400.00	3,947,022,914,145.44	204,486,040,254.56	95.1

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,175,651,029,600.00	3,956,469,961,163.38	219,181,068,436.62	94.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,175,651,029,600.00	3,956,469,961,163.38	219,181,068,436.62	94.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,857,924,800.00	5,109,800,422.02	748,124,377.98	87.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,805,424,800.00	5,010,928,297.02	794,496,502.98	86.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,500,000.00	98,872,125.00	(46,372,125.00)	188.3
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(30,000,000,000.00)	(14,556,847,439.96)	(15,443,152,560.04)	48.5
370001	"Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(30,000,000,000.00)	(14,556,847,439.96)	(15,443,152,560.04)	48.5
4	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		289,244,623.27	(289,244,623.27)	
5	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		272,431,134.83	(272,431,134.83)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2,323	2,260	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1,682	1,682	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	641	578	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6,633	6,438	195	97.1
620001	Удирдах ажилтан	208	194	14	93.3
620002	Гүйцэтгэх ажилтан	5,259	5,089	170	96.8
620003	Үйлчлэх ажилтан	1,163	1,152	11	99.1
620004	Гэрээт ажилтан	3	3	-	100.0

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		27,707,476,802.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ		27,558,437,579.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		20,882,675,382.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,357,099,260.91
210101	Үндсэн цалин		1,000,973,992.85
210102	Нэмэгдэл		991,449,432.81
210104	Урамшуулал		321,685,835.25
210105	Гэрээт ажлын хөлс		42,990,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		274,759,966.48
210201	Тэтгэврийн даатгал		235,338,380.85
210202	Тэтгэмжийн даатгал		9,756,895.66
210203	ҮОМШӨ-ний даатгал		5,198,342.85
210204	Ажилгүйдлийн даатгал		4,909,680.53
210205	Эрүүл мэндийн даатгал		19,556,666.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		62,065,325.79
210301	Гэрэл, цахилгаан		28,910,494.13
210302	Түлш, халаалт		15,705,391.72
210303	Цэвэр, бохир ус		15,369,439.94
210304	Байрны түрээс		2,080,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		171,802,777.72
210401	Бичиг хэрэг		73,868,612.94
210402	Тээвэр, шатахуун		54,526,102.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,343,481.90
210404	Ном, хэвлэл		30,069,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		9,995,580.00
2105	Нормативт зардал		131,728,498.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		400,000.00
210502	Хоол, хүнс		126,653,498.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		4,675,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		279,033,503.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		82,379,700.00
210602	Тавилга		31,581,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		26,100,000.00
210604	Урсгал засвар		138,972,003.00
2107	Томилолт, зочны зардал		637,268,998.24
210701	Гадаад албан томилолт		54,708,318.24
210702	Дотоод албан томилолт		582,560,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,121,084,179.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,117,826,649.51
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,038,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		186,030.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		33,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13,847,832,872.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7,649,872,196.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,197,960,675.75
212	ТАТААС		517,908,601.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		517,908,601.00

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	517,908,601.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,157,853,596.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,279,144,831.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	976,522.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,764,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,237,403,409.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	878,708,765.20
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	878,399,688.09
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	309,077.11
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	149,039,223.00
2200	Дотоод эх үүсвэрээр	149,039,223.00
220001	Барилга байгууламж	52,839,000.00
221001	Их засвар	36,200,223.00
222001	Тоног төхөөрөмж	60,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,528,872,371.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,528,872,371.21
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,494,669,153.02
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,479,725,872.59
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,697,651,750.88
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,856,825,594.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	346,923,370.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	168,318,939.62

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хүний хөгжил”-ийн зорилгод “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ” гэж заасан байна.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, шинжлэх ухааны салбарын зөв, оновчтой бодлогыг тодорхойлж, бодитой үр нөлөө үзүүлэх олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн онцлох ажлууд байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын, ялангуяа 5 настай хүүхдийн хамрагдалт төлөвлөсөн түвшнээс ахиж 94.1 хувьд хүрсэн, мөн төр, олон нийтийн оролцоог хангасан, хамтын хариуцлагатай байх зарчмыг баримтлан, хүүхдийг шим тэжээлийн тэнцвэртэй хоол хүнсээр хангах, эрүүл зөв хооллолтын дадлыг хэвшүүлэх зорилгоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын тодорхой хэсгийг эцэг эх, асран хамгаалагч нь хариуцах тухай хуулийн заалтыг 2024 оноос хэрэгжүүлж эхэлсэн;
- Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг батлуулж, хөтөлбөрийн шинэчлэлийг эхлүүлсэн. Энэ хүрээнд сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийг боловсруулж, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн түшиц 18 цэцэрлэг, ерөнхий боловсролын 27 сургуульд туршилтаар хэрэгжүүлж эхэлсэн;
- Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолоор “Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц”-ийг баталж, боловсролын түвшин хоорондын уялдаа, хөдөлмөрийн зах зээлтэй нийцлийг хангах суурь тогтолцоо бүрдсэн байна. Энэхүү бүтцийг олон улсын (ЮНЕСКО, НҮБХХ) дэмжлэгтэйгээр боловсруулсан нь шинжлэх ухааны үндэслэлтэй, оролцоонд суурилсан сайн жишиг болсон;
- Боловсролын хууль тогтоомжийн шинэчлэл, цахим боловсрол, хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэхтэй уялдсан санхүүжилтийн хүрээнд ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг 1-12 дугаар анги бүрээр тооцон шинэчилж, математик, англи хэл, мэдээлэл технологийн хөтөлбөрүүдийг олон улсын жишигт нийцүүлж сайжруулах, цахим сургалтын орчныг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтэц, үйлчилгээг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгэх, мэргэжлийн болон техникийн боловсрол мэргэжлийн өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх ажлыг эхлүүлсэн;
- Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлуулснаар Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагаас дэлхийн хэмжээнд дээд боловсролын салбарыг хамруулан гаргасан гэрээнд нэгдсэн 34 дэх улс болсон;
- Times higher Education байгууллага 2025 оны дэлхийн их сургуулиудын эрэмбэ, чансааг тодорхойлж, 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зарласан дүнгээр Монгол Улсын их сургууль албан ёсоор 1501+ дугаарт эрэмбэлэгдсэн нь Монгол Улсын дээд боловсролын салбарт олон улсын үнэлгээгээр танигдсан чухал эхлэл болсон;
- Засгийн газрын 2024 оны 222 дугаар тогтоолоор “Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг баталж тус журмын хүрээнд гадаадын 16 улсад үйл ажиллагаа явуулж буй 59 монгол хэл, соёлын төвийг төрөөс дэмжих эрх

зүйн үндсийг бий болгож, монгол хүүхдүүдийн хэл, соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд чухал алхам болсон;

- Боловсролын сайдын 2024 оны А/228 дугаар тушаалаар элсэлтийн босго оноог 490 болгон шинэчлэн тогтоосон нь дээд боловсролд элсэгчийн чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр нөлөөтэй шийдвэр болсон байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль зэрэг ерөнхий 13 хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль;
- Засгийн газрын 2024 оны "Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам" 72 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 39, 53 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2024 оны "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам" 194 дүгээр тогтоол

Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд багтах 1 төрийн өмчийн их сургууль, 9 төсвийн байгууллага, 1 төслийг хамарсан нийт 11 байгууллага, арга хэмжээнд төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бус 7 аудитыг гүйцэтгэсэн байна.

Аудитаар нийт 941.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 9.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 932.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, байгууллага болон салбарыг учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэн ажилласан ба албан шаардлагын биелэлт 96.0 хувь, улсын ахлах байцаагчийн тогтоосон актын биелэлт 100 хувьтай байна.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд байгууллагын дотоод хяналтаас аудитад хамааралтай хяналтыг авч үзэн, гүйцэтгэх шатанд хяналтын сорилыг хоёр дараалсан оноор зэрэгцүүлэн хэрэгжүүлэхэд, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийгдсэн аудитын дүнгээр залруулсан алдааны тоо 23.8 хувиар, санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчлийн тоо 10.6 хувиар, нийцлийн зөрчлийн тоо 54.4 хувиар өссөн бөгөөд энэ нь дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө сул, дотоод аудитын хүний нөөцийн хангалтгүй байдалтай шууд холбоотой болохыг харуулж байна. Тус газрын харьяанд нийт 1,806 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч дотоод аудитын албан хаагчийн орон тоо нийт 7 байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт, шалгалт зохион байгуулах нөхцөлийг хязгаарлаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Боловсролын сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бөгөөд тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн боловч зарим байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Боловсролын зээлийн сан, Их, дээд сургуулиудын бүртгэл, тайлагнал болон үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, хэт ерөнхий байдлаар боловсруулагдсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,043,134.9 сая төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	422,186.5	589,085.2	166,898.7
Богино хугацаат хөрөнгө оруулалт	144.5	58.2	-86.3
Авлага	321,038.3	347,712.4	26,674.1
Урьдчилгаа	59,584.2	174,325.9	114,741.7
Бараа материал	220,702.8	261,162.2	40,459.4
Бусад эргэлтийн хөрөнгө	1,320,990.3	1,747,828.5	426,838.2
Үндсэн хөрөнгө	5,119,839.4	5,387,448.5	267,609.1
Нийт хөрөнгө	7,464,486.0	8,507,620.9	1,043,134.9
Өр төлбөр	88,758.0	161,230.3	72,472.3
Засгийн газрын хувь оролцоо	7,375,728.0	8,346,390.6	970,662.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,464,486.0	8,507,620.9	1,043,134.9

Дээрх хүснэгтээс харахад бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 589,085.2 сая төгрөг болж, өмнөх оноос 166,898.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	7.8	3.5	(4.3)
Төгрөг	7.8	3.5	(4.3)
Банкинд байгаа бэлэн мөнгө	371,884.4	546,042.2	174,157.8
Төгрөг	361,624.3	536,864.4	175,240.1
Төрийн сангийн харилцах	285,735.5	460,057.8	174,322.3
Арилжааны банк дахь харилцах	75,522.7	76,638.3	1,115.5
Нэмэлт санхүүжилтийн харилцах	366.1	168.3	(197.8)
Гадаад валют	10,260.0	9,177.8	(1,082.3)
Монгол банк дахь харилцах	-	256.1	256.1
Арилжааны банк дахь харилцах	10,260.0	8,921.7	(1,338.3)
Замд яваа мөнгөн хөрөнгө	385.9	7.6	(378.3)
Хадгаламж	49,908.4	43,031.9	(6,876.5)
Дүн	422,186.5	589,085.2	166,898.7

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 92.7 хувь буюу 546,042.2 сая төгрөг нь банканд байгаа бэлэн мөнгө, 7.3 хувь буюу 43,031.9 сая төгрөг нь хадгаламж, харин 11.1 сая төгрөг нь касс болон замд яваа мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд Боловсролын ерөнхий газрын харьяа 1,752 сургууль, цэцэрлэг, мэргэжлийн болон насан туршийн боловсролын байгууллагын зарцуулагдаагүй 448,869.9 сая төгрөг, түрээсийн сурах бичгийн эргэлтийн сангийн 5,946.4 сая төгрөг, барьцаа хөрөнгийн 3,433.3 сая төгрөг, бусад 9 байгууллагын 1,722.5 сая төгрөг, техник хяналтын дансны 85.6 сая төгрөг зэрэг нийт 460,057.8 сая төгрөг байршиж байна.

Арилжааны банканд 2024 оны жилийн эцэст төгрөгөөр болон валютаар байршиж байгаа мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.1 Арилжааны банкны үлдэгдэл

Д/д	Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/	
		Төгрөгийн дансны үлдэгдэл	Валютын дансны үлдэгдэл
1	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	25,153.3	102.8
2	Монгол Оросын хамтарсан сургууль	14,308.1	-
3	Монгол Улсын Их сургууль	11,695.4	4,224.1
4	Монгол Улсын Боловсролын Их Сургууль	11,332.1	759.0
5	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль	6,862.6	2,071.6
6	Соёл Урлагийн Их Сургууль	2,886.7	1,209.1
7	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	2,627.2	503.5
8	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	702.6	-
9	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	659.8	51.5
10	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв	163.1	-
11	ШУТИС-ын политехникийн коллеж	124.1	-
12	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	121.9	-
13	Бусад 4 байгууллага	1.4	-
	Нийт	76,638.3	8,921.7

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 144.4 сая төгрөгийн дараа онд хэрэгжүүлэх төслийн болон Боловсролын ерөнхий газрын харьяа 14 байгууллагуудын 28.9 сая төгрөгийн ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд АШУҮИС-ийн 7.6 сая төгрөгийн үлдэгдлийг тайлагнажээ.

Мөнгөн хөрөнгийн хадгаламжийн дансанд төрийн өмчийн 4 их сургуулийн нийт 43,031.9 сая төгрөг байршиж байна. /МУБИС 15,000.0 сая төгрөг, МУИС 12,734.1 сая төгрөг, ШУТИС 11,575.5 сая төгрөг, АШУҮИС 3,722.3 сая төгрөг/

Аудитын илрүүлэлт

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон байгуулсан гэрээний заалтыг дагаж мөрдөөгүй, гэрээ байгуулаагүй зардал гаргасан 30,991.1 сая төгрөг /ЕБС-ийн 273 зөрчил 17,893.1 сая төгрөг, СӨББ-ын 372 зөрчил 8,418.3 сая төгрөг, БЕГ-ын 4 зөрчил 3,280.0 сая төгрөг, бусад байгууллагын 31 зөрчил 1,399.7 сая төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 1,464.9 сая төгрөг /ЕБС-ийн 72 зөрчил 338.7 сая төгрөг, АШУҮИС-ийн 261.7 сая төгрөг, СӨББ-ын 39 зөрчил 232.9 сая төгрөг, Нийслэлийн боловсролын газрын 154.3 сая төгрөг, бусад байгууллагын 29 зөрчил 477.3 сая төгрөг/;
- Батлагдсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, хяналтгүй зарцуулсан 4,566.8 сая төгрөг /БЕГ-ын аппаратын 1 зөрчил 3,510.3 сая төгрөг, ЕБС-ийн 59 зөрчил 617.7 сая төгрөг, СӨББ-ын 79 зөрчил 274.0 сая төгрөг, бусад байгууллагын 24 зөрчил 164.8 сая төгрөг/;
- Үдийн хоол, үдийн цайны зардлын батлагдсан норм зөрчсөн, зардлын зориулалт өөрчилсөн, зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй, хүүхдийн бүртгэлийн тоо зөрүүтэй, хяналт тавьж ажиллаагүй, ажиллагсдын хоолны мөнгийг илүү, дутуу, давхардуулан олгосон 2,818.7 сая төгрөг /ЕБС-ийн 133 зөрчил 1,714.8 сая төгрөг, СӨББ-ын 171 зөрчил 1,098.9 сая төгрөг, МББ-ын 2 зөрчил 5.0 сая төгрөг/;
- Боловсролын болон Эрүүл мэндийн сайд нарын хамтран баталсан албан ёсны жагсаалтад байхгүй үзлэг, шинжилгээнд ажилтнуудыг хамруулсан, эмнэлгийн үйлчилгээ үзүүлээгүй байхад төлбөрийг шилжүүлсэн, зориулалт бусаар зарцуулсан, баримтын бүрдэл дутуу, баталгаажаагүй, тайлан актгүй зэрэг 115.2 сая төгрөг /ЕБС-ийн 14 зөрчил 80.4 сая төгрөг, СӨББ-ын 27 зөрчил 29.9 сая төгрөг, МББ-ын 1 зөрчил 4.9 сая төгрөг/;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу тооцож олгосон, ээлжийн амралттай, томилолтоор ажилласан хүнд цалин давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийг төсвөөс олгож, гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрүүлсэн 5,628.3 сая төгрөг /СӨББ-ын 566 зөрчил 2,650.7 сая төгрөг, ЕБС-ийн 534 зөрчил 2,274.3 сая төгрөг, бусад байгууллагын 68 зөрчил 703.3 сая төгрөг/;
- Орлогын төлөвлөгөө тасалсан, хөрөнгийн түрээсийн болон сурах бичгийн түрээсийн орлого, орон нутгаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй, орлого бүртгээгүй, санхүүжилт дутуу авсан, мөнгөн сууриар бүртгэсэн 3,821.0 сая төгрөг /МББ-ын 7 зөрчил 2,524.0 сая төгрөг, ЕБС-ийн 30 зөрчил 584.3 сая төгрөг, СӨББ-ын 27 зөрчил 456.9 сая төгрөг, ААОДБАӨЗ-ны 1 зөрчил 214.9 сая төгрөг, бусад байгууллагын 3 зөрчил 40.9 сая төгрөг/.
- Боловсролын ерөнхий газар нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан боловч үлдэгдэл санхүүжилт 607.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын барьцаа хөрөнгийн дансанд хугацаа хэтрүүлэн байршуулж байна.
- Төсөв хүрэлцээгүй байгууллагуудын санхүүжилтийг нөхөх зорилгоор холбогдох журам зөрчин Боловсролын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/415 дугаар тушаалаар батлагдсан төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулж, нийт 150,272.9 сая төгрөгийг 1000 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 684 ерөнхий боловсролын сургууль, 29 насан туршийн боловсролын төвд шилжүүлсэн байна.

3.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 58.2 сая төгрөг болж, өмнөх оноос 86.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	144.5	58.2	(86.2)
Дүн	144.5	58.2	(86.2)

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын дансанд Боловсролын зээлийн сангаас 2016–2017 онд арилжааны таван банкаар дамжуулан олгосон жилийн 2 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг энгийн векселиэр бүртгэсэн бөгөөд зээлийн эргэн төлөлт 86.2 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.3 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 347,712.4 сая төгрөг болж, өмнөх оноос 26,674.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

			/сая төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	931.7	1,299.3	367.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	29,567.9	13,105.7	(16,462.2)
Татаас, санхүүжилтийн авлага	3,991.6	736.3	(3,255.3)
Зээлийн хүүгийн авлага	0.2	0.1	(0.1)
Дансны авлага /ТӨҮГ/	51.3	13.3	(38.0)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	49.4	110.7	61.3
Бусад авлага	28,657.5	63,070.1	34,412.5
Байгууллагаас авах авлага	26,884.3	60,791.9	33,907.5
Хувь хүмүүсээс авах авлага	1,773.2	2,278.2	505.0
Зээлийн авлага	257,788.6	269,376.9	11,588.3
Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	257,788.6	269,376.9	11,588.3
Дүн	321,038.3	347,712.4	26,674.1

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Нийт авлагын үлдэгдлийн 77.5 хувь буюу 269,428.5 сая төгрөг нь Боловсролын зээлийн сангийн зээлийн авлага, 12.8 хувь буюу 44,401.5 сая төгрөг нь Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын авлага, 9.7 хувь буюу 33,882.4 сая төгрөгийн авлага нь бусад 712 байгууллагын авлагын үлдэгдэл байна.

Нийт авлагын өсөлтөд Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын данснаас барилгын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу олгосон санхүүжилтийг авлагаар бүртгэсэнтэй холбоотойгоор 33,880.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр Засгийн газрын тэтгэлэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг, Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөр болон магистр, докторын сургалтад хамрагдаж, сангаас нийт 6,352.2 сая төгрөгийн зээл, тэтгэлэг авсан 68 суралцагч гэрээний үүргээ зөрчсөн;

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр Магистр, докторын сургалтад 432.5 сая төгрөгийн зээл авсан 8 суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаалбар бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад) сангийн архивд байхгүй;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай, зээн холбогдоггүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй 1,813.5 сая төгрөг /ЕБС-ийн 71 зөрчил 535.9 сая төгрөг, СӨББ-ын 59 зөрчил 330.5 сая төгрөг, МУИС-ийн 1 зөрчил 223.2 сая төгрөг, МББ-ын 9 зөрчил 210.5 сая төгрөг, БЕГ-ын аппаратын 1 зөрчил 136.0 сая төгрөг, бусад байгууллагын 8 зөрчил 377.4 сая төгрөг/.

3.4.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 174,325.9 сая төгрөг болж, өмнөх оноос 114,741.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	56,981.9	170,937.9	113,956.0
Урьдчилгаа тооцоо	2,602.3	3,388.0	785.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,701.3	2,196.8	495.5
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	482.9	367.7	(115.3)
Цалингийн урьдчилгаа	53.5	95.4	42.0
Томилолтын урьдчилгаа	364.6	728.1	363.5
Дүн	59,584.2	174,325.9	114,741.8

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 96.2 хувь буюу 169,599.6 сая төгрөг нь Боловсролын зээлийн сангийн, 3.8 хувь буюу 6,721.3 сая төгрөг нь бусад 11 байгууллагын үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 114,741.8 сая төгрөгөөр өсөхөд Боловсролын зээлийн сангийн нөхцөл заасан буцалтгүй тусламж, тэтгэлэгт 40,350.1 сая төгрөг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 39,373.5 сая төгрөг, Засгийн газрын нэрэмжит тэтгэлэгт 6,935.4 сая төгрөг, Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад зориулсан 11,970.7 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа дансанд бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Боловсролын зээлийн сангаас нийт 26,856.9 сая төгрөгийн тэтгэлэг авсан 205 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна;
- Монгол Улсын Их сургуулийн ректорын 2022 оны А/145 дугаар тушаалын дагуу дотооддоо хөгжүүлж буй "ERP систем"-ийн хөгжүүлэлтэд зарцуулсан 207.7 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэсэн ба уг тушаалын хэрэгжилт хангалтгүй;
- Монгол Улсын Их сургууль нь "Тунгалаг-Эрдэнэ" ХХК-тай 2011 онд байгуулсан 2011/19 дугаартай барилгын суурийг худалдах, худалдан авах гэрээний хүрээнд төлсөн 200.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй;
- Монгол Улсын Их сургууль нь "Евро Ази зам" ХХК-тай хичээлийн 8-р байрны зураг төсөл, төсөв боловсруулах гэрээг 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр байгуулж, гэрээний дагуу урьдчилгаа 40 хувь буюу 114.2 сая төлбөрийг шилжүүлсэн байна. Гэвч архитектур төлөвлөлтийн даалгавар аваагүй, нэмэлт гэрээ байгуулсан, барилгын ажлын дарааллыг зөрчсөн зэрэг шалтгаанаар гэрээний хэрэгжилт зогсож, 2022 оны 12 дугаар сарын 15-нд дуусах ёстой байсан ажлыг дуусгалгүй гэрээ цуцлагдсан боловч урьдчилгаа төлбөрийг буцаан төлүүлээгүй;
- Ажиллагсдаас урьдчилгаа дутуу суутгасан, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй 163.4 сая төгрөг /СӨББ-ын 4 зөрчил 83.2 сая төгрөг, ЕБС-ийн 12 зөрчил 74.7 сая төгрөг, МББ-ын 3 зөрчил 5.5 сая төгрөг/.

3.4.5 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 261,162.2 сая төгрөг болж, өмнөх оноос 40,459.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	39,117.8	44,936.1	5,818.3
Тусгай зориулалттай материал	33,412.5	39,456.2	6,043.8
Эм боох материал	5,705.4	5,479.9	(225.5)
Дуусаагүй үйлдвэрлэл	218.7	85.8	(132.9)
Бэлэн бүтээгдэхүүн	2,286.4	2,015.4	(271.0)
Хангамжийн материал	177,380.0	212,920.6	35,540.6
Бичиг хэргийн материал	4,967.6	5,973.3	1,005.7
Аж ахуйн материал	47,951.9	55,585.3	7,633.4
Сэлбэг хэрэгсэл	1,541.0	1,444.3	(96.7)
Түлш, шатах тослох материал	1,483.8	1,500.5	16.7
Барилгын засварын материал	4,086.5	3,802.9	(283.7)
Хүнсний материал	10,036.3	10,804.6	768.3
Бусад хангамжийн материал	107,312.9	133,809.9	26,496.9
Биологийн хөрөнгө	56.7	74.6	17.9
Мал амьтад	1,643.1	1,129.7	(513.3)
Дүн	220,702.8	261,162.2	40,459.4

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын дансны нийт үлдэгдлийн 46.3 хувь буюу 120,955.8 сая төгрөг нь ерөнхий боловсролын 696 сургуулийн, 37.5 хувь буюу 97,995.3 сая төгрөг нь сургуулийн өмнөх боловсролын 1,001 байгууллагын, 8.9 хувь буюу 23,316.9 сая төгрөг нь дээд боловсролын 6 байгууллагын, 6.2 хувь буюу 16,217.9 сая төгрөг нь мэргэжлийн боловсролын 32 байгууллагын, 0.5 хувь буюу 1,253.4 сая төгрөг нь аймаг, нийслэлийн 32 боловсролын газар, хэлтсийн, 0.2 хувь буюу 420.2 сая төгрөг нь насан туршийн боловсролын 28 байгууллагын, 0.4 хувь буюу 1,002.6 сая төгрөг нь бусад 7 байгууллагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Бараа материалын тодруулга тайлангаар худалдан авсан 344,003.6 сая төгрөг, хандиваар 23,894.6 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3,826.6 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 4,694.9 сая төгрөг, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 36,921.0 сая төгрөг, нийт 413,340.8 сая төгрөгөөр бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 338,863.6 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлсэн 13,957.4 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 8,813.6 сая төгрөг, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 11,246.7 сая төгрөг, нийт 372,881.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа материалыг буруу ангилан бүртгэсэн, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн 151.1 сая төгрөг /ЕБС-ийн 6 зөрчил 76.0 сая төгрөг, СУИС-ийн 3 зөрчил 34.8 сая төгрөг, СӨББ-ын 13 зөрчил 28.9 сая төгрөг, бусад байгууллагын 3 зөрчил 11.4 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, үр ашиггүй, шийдвэргүй, зориулалт бусаар зарцуулсан, хяналт хэрэгжүүлээгүй 1,225.5 сая төгрөг /ЕБС-ийн 52 зөрчил 848.7 сая төгрөг, СӨББ-ын 119 зөрчил 238.0 сая төгрөг, бусад байгууллагын 12 зөрчил 138.8 сая төгрөг/;
- Бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, зах зээлийн бодит үнээс зөрүүтэй, тооллогоор дутсан, устгалын акт үйлдээгүй, тайлан гаргаагүй 1,553.9 сая төгрөг /ЕБС-ийн 22 зөрчил 1,208.4 сая төгрөг, СӨББ-ын 17 зөрчил 165.8 сая төгрөг, бусад байгууллагын 7 зөрчил 179.7 сая төгрөг/;
- Бараа материалыг хэрэглээнээс илүү бэлтгэсэн, тогтоосон орц норм баримтлаагүй, хугацаа хэтэрсэн, ашиглалтгүй, эргэлт удааширсан 292.3 сая төгрөг /ШУТИС-ийн 1 зөрчил 198.6 сая төгрөг, СӨББ-ын 19 зөрчил 64.5 сая төгрөг, бусад байгууллагын 9 зөрчил 29.2 сая төгрөг/.

3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,747,828.5 сая төгрөг болж, өмнөх оноос 426,838.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,320,990.3	1,747,828.5	426,838.2
Дүн	1,320,990.3	1,747,828.5	426,838.2

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажилд олгосон 95,859.4 сая төгрөг, Боловсролын салбарын байгууллагуудын хөрөнгө оруулалтын 1,651,969.1 сая төгрөгийн санхүүжилт бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүйгээс нийт 168,119.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын өртөг бүхий 42 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй бөгөөд үүнээс Боловсролын сайдын хяналт тавих 59,569.1 сая төгрөгийн 47 арга хэмжээ, аймгийн Засаг даргын хяналт тавих 10,004.1 сая төгрөгийн 16 төсөл, нийслэлийн Засаг даргын хяналт тавих 11,153.7 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ хэрэгжилт удааширсан;
- Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд их засварын ажлаар тусгагдсан Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Сүмбэр баг дахь бага сургуулийн барилгын өргөтгөлийн их засварын 172.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны газраас модон байшингийн зураг төсөвтэйгөөр тендер зарлан, гүйцэтгэгчийг шалгаруулж, барилгын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Мөн Онцгой ерөнхий байдлын газраас уг ажил Магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажих боломжгүй талаар мэдэгдсэн тул гэрээг эцэслэн дүгнээгүй, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлээгүй, гэрээний алданги төлж үр ашиггүй зардал гаргах эрсдэлийг бий болгосон;
- Тайлант онд гэрээнд заасан хугацаанд багтаан ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн нийт 11,274.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээний барилгын ажлын гэрээг дүгнээгүй, алданги суутган тооцоогүй байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,387,448.5 сая төгрөг болж, өмнөх оноос 267,609.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,019,328.9	4,312,586.9	293,258.0
Барилга, байгууламж, орон сууц	3,410,450.7	3,615,050.4	204,599.6
Авто-тээврийн хэрэгсэл	11,056.9	15,625.5	4,568.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	323,649.7	407,443.3	83,793.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	113,522.7	140,471.0	26,948.3
Зам, гүүрний байгууламж	4,597.5	5,874.6	1,277.2
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	130.3	481.5	351.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,768.6	677.1	(2,091.5)
Бусад үндсэн хөрөнгө	45,624.8	51,476.3	5,851.5
Дуусаагүй барилга, байгууламж	66,292.4	33,206.1	(33,086.4)
Ном	41,235.2	42,281.1	1,045.9

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Биет бус хөрөнгө	1,100,510.6	1,074,862.0	(25,648.6)
Программ хангамж	12,957.2	11,467.7	(1,489.5)
Бусад биет бус хөрөнгө	1,087,553.4	1,063,394.3	(24,159.1)
Дүн	5,119,839.5	5,387,448.5	267,609.0

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны 70.9 хувь буюу 3,819,025.2 сая төгрөг нь Боловсролын ерөнхий газрын харьяа боловсролын байгууллагуудын, 14.5 хувь буюу 781,540.1 сая төгрөг нь Их дээд сургуулийн хөрөнгийн менежментийн төв ТӨҮГ-ын, 5.9 хувь буюу 317,936.0 сая төгрөг нь АШУҮИС-ийн, 2.3 хувь буюу 123,796.8 сая төгрөг нь ШУТИС-ийн, 2.0 хувь буюу 107,086.6 сая төгрөг нь МУИС-ын, 4.4 хувь буюу 238,063.8 сая төгрөг нь бусад 52 байгууллагын үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгийн дансны өсөлтөд дараах байгууллагуудын хөрөнгийн нэмэгдэл голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 583, 128 дугаар тогтоолын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан боловсролын салбарын байгууллагуудын 98 нэр төрлийн 428,294.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгө, мөн Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4 дэх зорилтын хүрээнд ("Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох") бий болсон 74 нэр төрлийн 30,631.6 сая төгрөгийн өртөг бүхий ариун цэврийн байгууламжийг хөрөнгийн бүртгэлд хамруулсан;
- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд байгуулсан Засгийн газар хоорондын гэрээний дагуу 23,752.8 сая төгрөгийн өртөг бүхий машин, тоног төхөөрөмж, 450.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл хүлээн авч, мөн 36,714.4 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулсан;
- Хөдөө аж ахуйн их сургууль нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 193 дугаар тогтоолын дагуу 6,996.6 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр барьсан номын сангийн барилгыг хөрөнгөнд бүртгэсэн;
- Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд нийт 13,073.6 сая төгрөгийн өртөг бүхий 77,191 ширхэг тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлсэн бөгөөд үүнээс Ерөнхий боловсролын 130 сургуульд 1,059.8 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсролын 37 байгууллагад 2,937.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил, Боловсролын ерөнхий газрын шинээр байгуулах байгалийн ухааны лабораторид 76.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зөрүүтэй тоолж, баталгаажуулсан, хөрөнгө биетээр оршин байхгүй, данс бүртгэлд тусгаагүй 8,288.9 сая төгрөг /СӨББ-ын 39 зөрчил 1,783.0 сая төгрөг, ЕБС-ийн 36 зөрчил 6,432.9 сая төгрөг, бусад байгууллагын 8 зөрчил 73.0 сая төгрөг/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглагдаж байгаа хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ, НӨХГ, ОНӨГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй, элэгдлийг зөрүүтэй тооцоолсон 1,259.7 сая төгрөг / СӨББ-ын 83 зөрчил 524.1 сая төгрөг, ЕБС-ийн 64 зөрчил 289.6 сая төгрөг, ИДСХМТ-ийн 1 зөрчил 167.7 сая төгрөг, бусад байгууллагын 14 зөрчил 278.3 сая төгрөг/;
- Хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа буруу ангилсан, зөрүүтэй, бөөн дүнгээр бүртгэсэн, тогтоол шийдвэргүй зардалд тусгасан, харилцагч байгууллагаас хүлээн авахдаа хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж, баримтжуулаагүй, цахим дэлгүүрээс өөр бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан, урсгал төсвөөс хөрөнгө бэлтгэсэн, хөрөнгийг биетээр хүлээн аваагүй орлогод тусгасан 1,542.5 сая төгрөг /ЕБС-ийн 35 зөрчил 962.0 сая төгрөг, МББ-ын 5 зөрчил 386.1 сая төгрөг, СӨББ-ын 33 зөрчил 134.6 сая төгрөг, бусад байгууллагын 11 зөрчил 59.8 сая төгрөг/;

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Газрын гэрчилгээ, кадастрын зурагтай зөрсөн, газар эзэмших хугацаа хэтэрсэн, санхүү бүртгэлд тусгаагүй, зөрүүтэй тайлагнасан 155.9 сая төгрөг /ЕБС-ийн 12 зөрчил 133.1 сая төгрөг, СӨББ-ын 10 зөрчил 22.8 сая төгрөг/;
- Шинжлэх ухаан технологийн их сургууль нь ТӨБЗГ-ын 2024 оны 466 дугаар тогтоолоор нийт 930.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг Эрчим хүчний сургуульд хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн боловч, хүлээлгэн өгсөн 533 ширхэг, 256.5 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгө нь ашиглалтад тохиромжгүй байсан тул сургуулийн зүгээс нягтлан бодох бүртгэлд орлогожуулаагүй, улмаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаагүй;
- Боловсролын зээлийн сан нь Гадаадын их, дээд сургуулийн суралцагчдын мэдээллийг бүртгэх, тэтгэлэг, зээл, тусламжийн бүртгэлийн программ хангамжийг хөгжүүлэх зорилгоор 2016 онд "ЕСМ" ХХК-тай 49.8 сая төгрөгийн үнийн дүнтэй 16/113 дугаар гэрээ, 2019 онд "Эрхэс электроникс" ХХК-тай 45.0 сая төгрөгийн үнийн дүнтэй 19/08 дугаар гэрээг тус тус байгуулсан байна. Гэвч аль аль программ хангамжийн хувьд хүлээж авах ажлын хэсгийг томилоогүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн акт үйлдээгүй, эх код, өгөгдлийн бааз болон үндсэн хөгжүүлэлтийн үр дүнгийн мэдээллийг бүрэн хүлээн аваагүй, системийн аюулгүй ажиллагааны туршилт хийгдээгүй, ашиглалт, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, программ хангамжийг ашиглалтад бүрэн оруулаагүй байна. Мөн программын оюуны өмчийн эзэмшигчийг гэрээнд тодорхой заагаагүй, хуучирсан технологид суурилсан хөгжүүлэлт хийсэн зэрэг нь цаашид хөгжүүлэлт хийх, ашиглах боломжийг хязгаарласан.

3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 161,230.3 сая төгрөг болж, өмнөх оноос 72,472.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	88,532.4	161,193.0	72,660.6
Өглөг	39,983.5	98,396.6	58,413.1
Ажилчидтай холбогдсон өглөг	1,758.5	2,639.5	881.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,948.1	1,538.7	(6,409.5)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	62.8	582.4	519.6
Бусад өглөг	30,214.0	93,635.9	63,421.9
Байгууллагад төлөх өглөг	29,651.0	92,934.7	63,283.8
Хувь хүмүүст төлөх өглөг	273.1	555.1	282.0
Татварын өглөг /ТӨҮГ/	94.5	85.0	(9.5)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	14.7	0.2	(14.5)
Дансны өглөг /ТӨҮГ/	180.8	60.9	(119.9)
Урьдчилж орсон орлого	48,548.9	62,796.4	14,247.5
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	399.6	452.3	52.7
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	24,760.4	33,754.1	8,993.7
Бусад урьдчилж орсон орлого	23,388.9	28,590.0	5,201.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	225.6	37.3	(188.3)
Урт хугацаат зээл	225.6	37.3	(188.3)
Төгрөг	183.4	-	(183.4)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	113.3	-	(113.3)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	70.0	-	(70.0)
Гадаад валют	42.2	37.3	(5.0)
Төслийн зээл	42.2	37.3	(5.0)
Дүн	88,758.0	161,230.3	72,472.3

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийт өр төлбөр дансны 53.2 хувь буюу 86,739.9 сая төгрөг нь Боловсролын ерөнхий газрын харьяа байгууллагуудын, 10.9 хувь буюу 17,787.0 сая төгрөг нь МУИС-ын, 10.8 хувь буюу 17,618.6 сая төгрөг нь ШУТИС-ийн, 8.0 хувь буюу 13,102.0 сая төгрөг нь МУБИС-ийн, 7.3 хувь буюу 11,936.1 сая төгрөг нь АШУҮИС-ийн, 4.1 хувь буюу 6,713.2 сая төгрөг нь ХААИС-ийн, 2.1 хувь буюу 3,398.3 сая төгрөг нь боловсролын салбарын барьцаа, 1.2 хувь буюу 2,037.8 сая төгрөг нь СУИС-ийн, 2.4 хувь буюу 3,857.3 сая төгрөг нь бусад 20 байгууллагын үлдэгдэл байна.

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 72,472.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд дараах байгууллагуудын өглөгийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын өглөг, барьцаа өмнөх оноос 43,412.9 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Оюутнуудын сургалтын төлбөрийн урьдчилгаа өмнөх онтой харьцуулахад МУИС-д 6,975.3 сая төгрөг, АШУҮИС-д 3,506.6 сая төгрөг, ШУТИС-д 3,448.7 сая төгрөг, ХААИС-д 2,810.5 сая төгрөг, МУБИС-д 1,987.8 сая төгрөгөөр тус тус өссөн.

Урт хугацаат өр төлбөр дансанд ШУТИС-ийн Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-аас балансаас балансад шилжүүлэн авсан 2032 онд төлөгдөж дуусах халаалтын цогц төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр 37.3 сая төгрөг байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 1,717.2 сая төгрөг /ЕБС-ийн 66 зөрчил 915.3 сая төгрөг, Монгол улсын консерваторын 1 зөрчил 323.0 сая төгрөг, МББ-ын 7 зөрчил 277.9 сая төгрөг, СӨББ-ын 41 зөрчил 118.3 сая төгрөг, бусад байгууллагын 3 зөрчил 82.7 сая төгрөг/.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 8,346,390.6 сая төгрөг болж, өмнөх оноос 970,662.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,153,966.6	1,101,910.5	(52,056.2)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	765,568.6	765,568.6	-
Хуримтлагдсан үр дүн	4,247,144.7	5,306,504.3	1,059,359.6
Өмнөх үеийн үр дүн	3,233,624.4	4,374,624.3	1,140,999.9
Тайлант үеийн үр дүн	1,013,520.3	931,880.0	(81,640.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,048.0	1,172,407.3	(36,640.8)
Дүн	7,375,728.0	8,346,390.6	970,662.6

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Нийслэлийн Ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний Засгийн газраас оруулсан хөрөнгийн дүн санхүүгийн тайлангаас 404.8 сая төгрөгийн зөрүүтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,519,114.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 7,966.6 сая төгрөг, дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс (30,000.0) сая төгрөгийг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 6,497,080.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 969,157.9 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,299,709.5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар нийт зардлыг 4,228,213.4 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн тодотголоор урсгал зардлаас 54,888.7 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 21,815.8 сая төгрөгийг бууруулж, нийт зардлыг 4,150,472.6 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 1,036.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 5,857.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас 5,109.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 748.1 сая төгрөгөөр давуулан бүрдүүлсэн байна.

Боловсролын зээлийн сангийн зээлийн эргэн төлөлтөөс 30,000.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 14,556.8 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөснөөс 15,443.2 сая төгрөг буюу 51.5 хувиар тасарсан байна.

Хүснэгт 12. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт

					/сая төгрөгөөр/
Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	5,805.4	5,010.9	794.5	86.3
2	Туслах үйл ажиллагааны орлого	52.5	98.9	(46.4)	188.3
Дүн		5,857.9	5,109.8	748.1	87.2

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,947,039.7 сая төгрөг буюу 95.1 хувьтай байна. Энэ нь хөрөнгийн зардлын гүйцэтгэл 176,164.1 сая төгрөгөөр тасарсан буюу дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 13. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/сая төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	718010 Сургуулийн өмнөх боловсрол	1,039,314.6	1,035,269.5	4,045.1
2	718020 Ерөнхий боловсрол	1,983,457.3	1,979,306.4	4,150.9
3	718030 Дээд боловсрол	108,880.3	104,215.0	4,665.3
4	718040 Мэргэжлийн боловсрол	213,537.5	200,847.3	12,690.2
5	718050 Шинжлэх ухаан, технологи	7,302.8	7,226.7	76.1
6	718060 Насан туршийн боловсрол	11,341.5	11,335.8	5.7
7	718070 Тусгай хэрэгцээт боловсрол	7,848.9	7,831.1	17.8

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	718080 Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	767,097.2	588,334.0	178,763.2
9	718090 Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ	12,679.7	12,624.9	54.8
10	722010 Жендерийн тэгш байдлыг хангах	49.1	49.0	0.1
Нийт		4,151,508.9	3,947,039.7	204,469.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд оны эхэнд 346.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба эх үүсвэрийг Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 2,494.7 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 15,479.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт туссан хөрөнгөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 4,697.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 4,856.8 сая төгрөг, нийт 27,528.8 сая төгрөгөөр бүрдүүлж, урсгал зардалд 27,558.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 149.0 сая төгрөгийг зарцуулж, 878.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, оны эцэст 168.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд 16 төсөл хэрэгжүүлэгч нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 14. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Төсөл, хөтөлбөрийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн зорилго	Хэрэгжих хугацаа	Төслийг санхүүжүүлэгч улс, байгууллага, санхүүжилтийн хэмжээ, зарцуулалт
1	"Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах" "Sustaining Access to and Quality of Education during Economic Difficulties Project"	Боловсролын яам	(i) Улаанбаатар хот ба зарим аймгийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалт буурч буйг зогсоох, (ii) эхлүүлээд буй сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийг дуусгахад дэмжлэг үзүүлэх, (iii) шинэ хөтөлбөрт тохирох дагалдах сургалтын болон заах материалын хангамжийг баталгаажуулах, (iv) шинэ хөтөлбөр, үнэлгээний шаардлагыг хангахын тулд багш, менежерүүдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, ба (v) боловсролын үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх	2020.11-2024.08	Азийн хөгжлийн банк 50.0 сая ам.доллар
2	Инженер технологийн дээд боловсрол төсөл "Higher Engineering Education Development" Project	Боловсролын яам, ШУТИС	Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчин, чанарыг шинэчлэн сайжруулах, нийт 1000 инженерийг Япон Улсад бэлтгэж эх орондоо ажиллуулах эрхэм зорилготой.	2014.03-2026.06	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/ 7.5 тэрбум иен

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	"Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн хотхоны өргөтгөл" төсөл GMIT Campus Extension Project	Боловсролын яам	Сургуулийн номын сан, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах замаар GMIT кампус дахь боловсрол, судалгааны орчныг сайжруулахад оршино. Одоо байгаа болон нэмэлт шинээр төлөвлөж буй лаборатори, сургалтын танхимуудыг иж бүрэн тоноглож, Их сургуулийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх	2020.12-2024.12	ХБНГУ-ын Сэргээн Босголтын Зээлийн Банк 7 сая евро
4	Атал Бихари Вайпайе нэрэмжит мэдээллийн технологи, холбоо, аутсорсингийн төв байгуулах төсөл Atal Bihari Vajpayee Center for Excellence in Information Technology & Communication and Outsourcing Center Project	Боловсролын яам	Олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийн хөгжүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийг байгуулж, улмаар мэдээллийн технологийн салбараар дамжуулан Монгол Улсын экспортыг дэмжихэд төслийн зорилго оршино.	2015.12 - 2024.12	Энэтхэг Улсын Засгийн газар /Эксим банк/ 20.0 сая ам.доллар
5	АШУУИС-ийн эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл	Боловсролын яам	АШУУИС-ийн эмнэлэгт тусламж үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай нийт тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн 80 орчим хувь буюу 270 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл төслийн санхүүжилтээр Япон улсаас нийлүүлэх	2021-2024	Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлтэй зээл 7.5 сая ам.доллар
6	Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл	Боловсролын яам, Азийн Хөгжлийн Банк	Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийн боловсролын чанар, хүртээмж сайжруулах	2020.11 - 2024.02	Ядуурлыг Бууруулах Япон Сангийн / 2 сая ам. доллар
7	"Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх төсөл" СТАРТ 2	Боловсролын яам, Япон Улсын Гадаад хэргийн яам	2-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлнэ	2020. 09 - 2024. 02	Япон улсын засгийн газар ЖАЙКА байгууллага 3,465 сая ам.доллар
8	ЕБС-ийн "Үдийн хоол"-ны үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төсөл	Боловсролын яам	Монгол Улсын ерөнхий боловсролын бага, дунд сургуулиуд шим тэжээлийн тэнцвэрт байдлыг хангасан, эрүүл аюулгүй үдийн хоолоор хангахад дэмжлэг үзүүлэх	2021 - 2025	ЖАЙКА /ЯОУБ/ 2,6 сая ам.доллар
9	Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл	Боловсролын яам	Мэргэжлийн багшийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, "чадамжийн төв"-ийг хөгжүүлэх замаар барилга, цахилгаан, механикийн мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг сайжруулахад оршино.	2024.01 - 2025.12	ХБНГУ Засгийн газар 2 сая евро
10	БСХДХТ 2030-ийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төсөл	Боловсролын яам	Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллагын механизм, чадавхыг бэхжүүлэх, Онлайн зайн сургалт, үнэлгээний систем, нөөцийг сайжруулах, Багш нарын мэргэжил дээшлүүлэх	2022 - 2024	Азийн хөгжлийн банк 0.5 сая ам.доллар
11	Ковид-19-ийн дараах боловсролын салбарыг дэмжих төсөл	Боловсролын яам	Сурагчийг үнэлэх багшийн мэдлэг чадварыг сайжруулах, багшийн хосолсон сургалтаар хичээл заах ур чадварыг сайжруулах, ковид 19-ийн дараах сургуулиудын менежментийг сайжруулах, Ковид 19-ийн дараах хичээл хоцрогдолд нөлөөлж буй хүчин зүйлсийг олж илрүүлэх	2022-2024	Азийн хөгжлийн банк 0.55 сая ам.доллар
12	Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл EQUAL төсөл	Боловсролын яам	GPE олон улсын байгууллагаас олгодог Multiplier fund санхүүжилт нь одоо шинээр хэрэгжиж буй төслүүдэд нэмэлт санхүүжилт болж дэмжлэг үзүүлэх зорилготой санхүүжилт юм.	2022-2025	Глобал Партнершип фор эдүкэйшн 5 сая ам.доллар

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (GMIT) III	Боловсролын яам	Монгол-Германы ашигт малтмал, технологийн их сургуулийг олон улсын чиг хандлагад нийцсэн, чанарыг эрхэмлэсэн их сургуулийн хувьд эрдэс түүхий эдэд түшиглэсэн эдийн засгийн хөгжлийг хангахад чиглэсэн нарийн мэргэжлийн ба удирдах ажилтан бэлтгэх, мөн шинжлэх ухаан, технологийн мэдлэг, туршлага бий болгоход оршино.	2024.01-2026.12	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ) 4 сая евро
14	ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсөл	Боловсролын яам, КОЙКА	А. Үндэсний хэмжээний сургуулийн хоолны үйлчилгээний үйл ажиллагааны удирдамжийг боловсруулж, загвар сургуулиудад дэмжлэг үзүүлэх замаар институцийн суурийг бий болгох Б. Сургуулийн хоолны үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх төв, түүний боловсролын хөтөлбөрөөр дамжуулан сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг удирдан чиглүүлэх	2022-2026	КОЙКА 8,000,000 ам.доллар
15	ХААИС-ийн сургалт, судалгаа, Аж үйлдвэрийн уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төсөл	Боловсролын яам, ХААИС, КОЙКА	А. Бүрэлдэхүүн хэсэг 1. Малын шинжлэх ухаан, биотехнологийн сургуулийн салбар-академийн уялдаа холбоотой тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах Б. Бүрэлдэхүүн хэсэг 2. Мал аж ахуйн технологийг дэмжих төв (цаашид "Төв" гэх) байгуулж, лабораторийн орчны суурийг тавих. С. Бүрэлдэхүүн хэсэг 3. Мал аж ахуйн өндөр түвшний мэргэжилтнүүдийг дэмжих, гарааны үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх	2022-2026	КОЙКА 5,000,000 ам.доллар

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн орчныг сайжруулах, дотоод аудит, хяналт хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор М.Ганбаатар, Я.Марал-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 1/1326 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 5,484,593.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 54,846.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайд 2022 оны А69 дүгээр тушаалаар төсвийн шууд захирагч нарт төсвийн хэмнэлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тушаалын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар үнэлгээ хийх чиглэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.

Эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж дүрэмт хувцас худалдан авсан, бараа, бэлэн бүтээгдэхүүн нөөцөлсөн, сонин хэвлэл захиалсан, цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан зэрэг 115.2 сая төгрөгийн нийт 40 зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 20 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой нийт 254,449.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9.1 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 196,758.8 сая төгрөгийн 254 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 57,434.0 сая төгрөгийн зөрчилд 1108 зөвлөмж өгч, 247.7 сая төгрөгийн 15 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний 633 байгууллага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 60,660.4 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй, хугацаа хоцроон мэдээлсэн зөрчилтэй байна. Эдгээр байгууллагаас 463 байгууллагад зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 162 байгууллагад албан шаардлага, 8 албан хаагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 692 сургууль, 1003 цэцэрлэг, 41 мэргэжлийн боловсролын байгууллагын нийт 2534 барилга байгууламжаас 322 барилга нь сургалтын орчны стандартад нийцээгүй байна. Үүнээс ерөнхий боловсролын сургуулийн 1088 барилгаас 103, цэцэрлэгийн 1370 барилгаас 207, мэргэжлийн боловсролын байгууллагын 76 барилгаас 12 барилга нь стандартын шаардлага хангахгүй байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын сургалтын орчныг стандартын шаардлагад нийцүүлэх, барилга байгууламжийг үе шаттайгаар засвар хийх, шинэчлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,807 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 851 байгууллагын тайланг аудитын түүвэрт хамруулж, 885 байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй", 68 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", 2 байгууллагын санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгсөн бол 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулахад залруулсан алдааны тоо 23.8 хувь, санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчлийн тоо 10.9 хувь, нийцлийн асуудлаарх зөрчлийн тоо 54.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-т "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг СНАГ-2025/022/НА-СТА-ТЕЗ

байх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн тоо өсөж байгаад дүн шинжилгээ хийх, хяналтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 7 зөвлөмж, зөрчил арилгуулах 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлэхийг өмнөх аудитын тайлангаар мэдэгдсэн боловч хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн 2023 оны аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн зөрчил арилгуулах болон хариуцлага тооцуулах албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцох үндэслэл болох тул хэрэгжилтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4. Сүүлийн гурван жилийн хугацаанд төрийн өмчит зургаан их сургуулийн нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 3.1 хувиар, орлого 19.7 хувиар өссөн боловч цэвэр ашиг жилд дунджаар 15.7 хувиар буурсан нь ашигт ажиллагаа болон үр ашгийн үзүүлэлт сул хэвээр байгааг харуулж байна. Энэ нь орлогын бүтэц, зардлын удирдлагын стратеги тодорхойгүй, зорилтот чиглэлгүй байсантай холбоотой.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын эрх хэмжээ 1-т "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвхөн сургалтын төлбөрт түшиглэсэн орлогын хамаарлыг бууруулж, эрдэм шинжилгээний ажил, судалгааны төсөл, захиалгат үйлчилгээ, оюуны өмчийн ашиглалт зэрэг эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлого боловсруулах, зардлын удирдлагын стратегийг тодорхой болгож, ашигт ажиллагааны үнэлгээ, хяналтыг сайжруулан, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дотоод чадавхыг бэхжүүлэх талаар зөвлөмж өгөв.

5. Төрийн өмчит зургаан их сургуулийн Сүүлийн гурван жилийн нийт өр төлбөрийн дундаж өсөлт 12,454.3 сая төгрөг бол жилийн дундаж алдагдал 37,663.6 сая төгрөг ба санхүүгийн алдагдлыг өрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нь байгууллагын төлбөрийн чадвар, хөрвөх

чадварыг сулруулж, үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж болзошгүй бөгөөд хөрөнгийн удирдлагыг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлээгүйтэй холбоотой байж болзошгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Төрийн өмчийн талаарх яам, тусгай газрын эрх хэмжээ 1-т "Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн удирдлагыг оновчтой төлөвлөж, зардал, өрийн менежментийг сайжруулах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

6. Төрийн өмчийн зургаан их сургууль нь сургалт, судалгаа, олон улсын хамтын ажиллагаа зэрэг олон үзүүлэлт дээр үндэслэн гардаг олон улсын их, дээд сургуулиудын албан бус үзүүлэлтээр 1000-аас доош байрлалд эрэмбэлэгдэж байна.

Энэ нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.1-т "Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ын 6-д Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байна", II үе шат (2031-2040)-ын 3-т "Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байна" гэж тусгасантай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Дотоодын боловсрол, судалгааны чанарыг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, чанар, нөлөөллийг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

7. Боловсролын сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай холбоотой дараах асуудлуудаар үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Үүнд:

А. Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал насан туршийн суралцахуйн төвд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийг батлаагүй, дэмжлэг үзүүлээгүй.

В. Сум, дүүргийн Засаг дарга нар насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг батлаагүй;

С. Мэргэжлийн болон техникийн боловсролын үнэлгээнд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлоогүй, Мэргэжлийн болон техникийн боловсролын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаар батлуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", Боловсролын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн 29.1.4-т "насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, санхүүжилтийг батлах", 31 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн 31.1.5-д "насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх",

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Мэргэжлийн болон техникийн боловсролын стандарт нь Боловсролын ерөнхий хуулийн 16.1-д зааснаас гадна мэргэжлийн болон техникийн боловсролын үнэлгээнд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлно", 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага батална" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагуудтай уялдаа холбоо сайжруулж, эрх зүйн хэрэгжилтийг хангах, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, СНАГ-2025/022/НА-СТА-ТЕЗ

боловсролын стандарт, үнэлгээний баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

8. Боловсролын зээлийн сангийн зээлээр суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурлаас батлаагүй байхад суралцагчтай байгуулсан гэрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэх зохицуулалт хийсэн, төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулсан дараах асуудлууд байна. Үүнд:

А. Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ыг үндэслэн байгуулсан Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна.

Энэ зохицуулалтаар бакалаврын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан нийт 40,115,730.23 ам.долларын сургалтын зээл авсан 350 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

В. Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг үндэслэн байгуулсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ"-ний 3.7-д "Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг 'Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай' хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна" гэж заасан байна.

Энэ зохицуулалтаар Магистр, докторын боловсрол эзэмшихээр гэрээ байгуулан 8,988,279.79 ам.долларын зээл авсан 296 суралцагчийн хөнгөлөлт, чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй, зээл төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно", Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "хуульд үндэслэх", 4.2.5-д "зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн нөхцөл, эргэн төлөлт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн эрх зүйн зохицуулалтыг яаралтай тодорхой болгож, холбогдох журмын төслийг Улсын Их Хуралд өргөн барих, энэ чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах талаар зөвлөмж өгөв.

9. Боловсролын зээлийн сангаас зээл авсан суралцагчид сургуулиа төгссөний дараа Монгол Улсад заавал ирж ажиллах үүрэг хүлээхтэй холбоотой эрх зүйн нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь төгсөгчид эх орондоо эргэн ирж, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх үндсэн зорилгыг хангахгүй байх, төсөв үргүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т "Бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлнэ", Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-

д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаадын их, дээд сургуульд Боловсролын зээлийн сангийн зээлээр суралцсан төгсөгчдөд Монгол Улсад заавал ирж ажиллах үүргийг тодорхой, хэрэгжих боломжтой нөхцөлөөр зохицуулсан эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулж, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах зөвлөмж өгөв.

10. Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр магистр, докторын үндсэн хөтөлбөрт хамрагдах суралцагчдыг сонгон шалгаруулах шалгуурт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын эрэмбэ, сургалтын чанарын талаар зохицуулалтгүй байна. Үүний улмаас сургалтын чанар хангалтгүй их, дээд сургуулиуд тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, төсөв үргүй зарцуулагдах эрсдэл үүсэж болзошгүй юм.

Энэ нь Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12-т "Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Магистр, докторын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах суралцагчдыг сонгон шалгаруулах шалгуурт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиудын эрэмбэ, сургалтын чанарын үзүүлэлтийг тусгах эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулж, дээд шатны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах, хэрэгжилтийг хангах замаар төсвийн хөрөнгийг үр ашигтай, зорилтот түвшинд зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх зөвлөмж өгөв.

11. Боловсролын салбарын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг хэлэлцэж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах үйл ажиллагаа хангалтгүй байна. Тухайлбал, салбарт хэрэгжиж буй 13 төслөөс 6 төслийн мэдээлэл Төслүүдийн удирдлагын нэгдсэн цахим систем (ODAMIS)-д бүрэн байршаагүй, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, үнэлгээ, дотоод аудитын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 10.5-д "Салбарын хэмжээнд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, дүгнэлт зөвлөмжийг хэлэлцэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч биелэлтэд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангах, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ", 10.7.2-т "төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж, энэ журмын 15 дугаар хавсралт дахь маягтын дагуу тайланг нэгтгэн, дүгнэлт, зөвлөмж, танилцуулгын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор албан бичгээр болон цахим системээр танилцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй боловсролын төслүүдийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, удирдлага зохицуулалтаар хангах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор бүх төслийн мэдээллийг ODA MIS системд бүрэн байршуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын оролцоог идэвхжүүлэн тогтмол хяналт, үнэлгээ хийж, үр дүнг шийдвэр гаргах түвшинд хэлэлцэн, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх зөвлөмж өгөв.

12. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь төсөл хэрэгжиж дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг хийж цахим системээр тайлагнаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 10.10-т "Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төсөл, арга хэмжээний үр дүнгийн үнэлгээг уг төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусахаас нэг сарын өмнө хийж цахим системд тайлагнах ба төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь төсөл хэрэгжиж дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг хийж цахим системээр тайлагнана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг журамд заасан хугацаанд хийж, цахим системд байршуулан тайлагнах, хэрэгжилтийг сайжруулах, хяналт, зохицуулалтыг үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээний санхүүгийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, тайланг гаргаагүй, төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд хяналт-шалгалт хийгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 10.14-т "Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээний санхүүгийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, тайланг үнэн зөв гаргах, төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд хяналт-шалгалт хийх бөгөөд төслийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ажлын чанарыг бүрэн хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээний санхүүгийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг тухай бүр гаргаж, журамд заасан хугацаанд тайлагнах, мөн барилга байгууламж, их засварын ажлын хэрэгжилтэд хяналт-шалгалт тогтмол зохион байгуулж, хэрэгжилтийн ил тод байдал, үр нөлөөг хангаж ажиллах талаар зөвлөмж өгөв.

14. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд "төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" гэсэн статустай бүртгэгдсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд нэгтгэгдэн тайлагнаж байна. Гэвч санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар гаргаж байгаа нь байгууллагын эрх зүйн статус болон санхүүгийн тайлагналын ангилал хооронд нийцэлгүй байдал үүсгэж байна. Тус байгууллага төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар тайлагнаж буй нөхцөлд өөрийн орлогыг улсын төсөвт тусган батлуулж, орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлэх зохицуулалтыг хангаж ажиллахаар байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3-т "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 4.4-т Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т

“Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь байгууллагын эрх зүйн статус болон санхүүгийн тайлагналын ангиллыг нийцүүлэх арга хэмжээг авч, төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд тайлагнах эсхүл төсөвт байгууллагын маягтаар санхүүгийн тайлан гаргаж байгаа тохиолдолд орлого, зарлагын төлөвлөгөөг улсын төсөвт тусган батлуулж, орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлэх зохицуулалтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн боловсролын барилга байгууламжийн стандартын хангалт, санхүүгийн тайлагнал, дээд боловсролын байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, гадаад зээлийн төслүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, орон нутгийн санхүүжилт, мэргэжлийн болон техникийн боловсролын стандартын хэрэгжилт зэрэг үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын зарим шаардлагад бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 7 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага 94.4 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	1	-	1	-	70.0
2	Зөвлөмж	7	-	7	-	97.1
3	Хариуцлага тооцох АШ	1	-	1	-	100.0
	Нийт дүн	9	-	9	-	94.4

Өмнөх аудитаар “Шинжлэх ухааны паркийн захиргаа нь аж үйлдвэр, судалгаа шинжилгээ, технологийг хөгжүүлэх Шинжлэх ухааны парк шинээр байгуулах, инновацийн эко орчин бүрдүүлэх эрхэм зорилготой, Монгол Улсад өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр 2017 онд байгуулагдсан боловч өндөр технологийн аж үйлдвэр хөгжих суурь дэд бүтэц болсон Шинжлэх ухааны парк байгуулаагүй” зөрчилд өгсөн “Өндөр технологийн аж үйлдвэр хөгжих суурь дэд бүтэц болсон Шинжлэх ухааны парк байгуулах талаар судалгаа хийх, олон улсын туршлагыг судлах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллах” зөвлөмжийн хэрэгжилт 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах асуудлыг харьяаллын дагуу Монгол Улсын тэргүүн шадар сайдад шилжүүлсэн.

Мөн боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох зорилтын хэрэгжилт удаашралтай байгаатай холбогдуулан уг зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Боловсролын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн нэгжүүдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнд төвлөрсөн аудит хийхэд багийн анхаарлыг хандуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 409,590.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2,204.2 сая төгрөгийн зөрчилд 685 төлбөрийн акт тогтоож, 235,352.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 918 албан шаардлага хүргүүлж, 171,698.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1458 зөвлөмж өгч, 334.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 18 албан шаардлага хүргүүлээ.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 121,897.7 сая төгрөгийн 1553 алдаа илэрснээс 120,953.0 сая төгрөгийн 1492 алдааг аудитын явцад залруулж, 944.7 сая төгрөгийн залруулаагүй алдаанд 61 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 409,590.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 54,846.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Харьяа 1806 байгууллагаас 955 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 851 байгууллагыг түүвэрт хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Санал дүгнэлт гаргасан 955 байгууллагаас 885 байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт, 67 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт, 2 байгууллагын санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгч 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа. Үүнээс Говь-Алтай аймгийн Цогт сумын Ерөнхий боловсролын сургууль, Ховд аймгийн Ховд сумын ерөнхий боловсролын сургууль "Сөрөг" дүгнэлт, Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургууль "Татгалзсан" дүгнэлт өгсөн.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит

5.2.1 Аудитаар илэрсэн зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүнд зардал хүлээн зөвшөөрөлт болон худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 328.4 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэн тул баталгаажсан гүйцэтгэлд үндэслэн зардлыг хүлээн зөвшөөрөх, дотоод хяналтыг сайжруулах талаар 1 зөвлөмж өгч, зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Албан шаардлага

1. Боловсролын сайдын 2024 оны А/234 дүгээр тушаалын дагуу "Инвомед трейд" ХХК-аар гүйцэтгүүлсэн, 60.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Нүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийн харааны хэрэглэгдэхүүн худалдан авах" арга хэмжээг шууд гэрээ байгуулан боловсролын сургалтын 50 байгууллагаар дамжуулан хэрэгжүүлсэн байна. Гэвч 0–18 насны хүүхдүүдийн амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн хариуцдаг бөгөөд шаардлагагүй зардал гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т

"Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Шимтгэлийг дараах байдлаар эрүүл мэндийн даатгалын санд хариуцан төлнө: 8.2.3. энэ хуулийн 6.1.5-6.1.8, 6.1.10-т заасан даатгуулагчийн шимтгэлийг улсын төсвөөс сар бүр", 9 дүгээр зүйлийн 9.1-т "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад дараах тусламж, үйлчилгээ хамаарна: 9.1.2.амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Боловсролын сайдын 2024 оны А/31, А/123, А/162, А/191, А/223, А/298 дугаар тушаалын дагуу 12 дугаар сард зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэгчийг худалдан авах ажиллагааны дагуу сонгон шалгаруулаагүй, Туушин зочид буудал ХХК-тай нийт 68.1 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулж, төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиггүй зарцуулсан болон худалдан авах ажиллагааг зохих журмаар зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Боловсролын сайдын 2024 оны А/130 дугаар тушаалаар Шинжлэх ухааны академид эрх шилжүүлсэн, 200.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Монгол Улсын түүхийг туурвин хэвлүүлэх" ажлын гүйцэтгэлд үнэлгээ, баталгаажуулалт хийгээгүй, тус ажил эцэслэн дуусаагүй байхад зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гүйцэтгэл нь эцэслэн дуусаж, үнэлгээ баталгаажуулалт хийгдээгүй ажлыг зардалд бүртгэхгүй байх, зөвхөн баталгаажсан гүйцэтгэлд үндэслэн зардлыг хүлээн зөвшөөрөх, дотоод хяналтыг сайжруулж, ижил төстэй алдааг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

№	Байгууллага нэгжийн нэр	Байгууллагын тоо	2024 оны санхүүгийн тайлангийн аудит			Дүгнэлт					Аудит хийсэн байгууллагын нэр	
			ҮАГ	АНТАГ	АХЭ	Өөрчлөлтий	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт гаргахаас татгалзсан	Түүвэрт		Аудитад хамрагдаагүй
1	Боловсролын сайд ТЭЗ	1	1				1					Үндэсний аудитын газар
2	Боловсролын ерөнхий газар ТТЗ	1,743	3	940	800	834	62	2	1	844	-	Үндэсний аудитын газар
3	Боловсролын яам	1	1			1						Үндэсний аудитын газар
4	Архангай аймгийн Боловсролын газар	1			1	1						Бизкон Аудит ХХК
5	Баян-Өлгий аймгийн Боловсролын газар	1		1		1						Баян-Өлгий аймаг дахь ТАГ
6	Баянхонгор аймгийн боловсролын газар	1		1		1						Баянхонгор аймаг дахь ТАГ
7	Булган аймгийн Боловсролын газар	1		1		1						Булган аймаг дахь ТАГ
8	Говь-Алтай аймгийн боловсролын газар	1		1		1						Говь-Алтай аймаг дахь ТАГ
9	Говьсүмбэр аймгийн Боловсролын газар	1			1	1						Платиниум прогресс аудит ХХК
10	Дархан-Уул аймгийн Боловсролын газар	1		1		1						Дархан-Уул аймаг дахь ТАГ
11	Дорнод аймгийн боловсролын газар	1		1		1						Дорнод аймаг дахь ТАГ
12	Дорноговь аймгийн боловсролын газар	1		1						1		Дорноговь аймаг дахь ТАГ
13	Дундговь аймгийн Боловсролын газар	1			1	1						Си Пи Ти Эй Аудит ХХК
14	Завхан аймгийн Боловсролын газар	1		1		1						Завхан аймаг дахь ТАГ
15	Орхон аймгийн боловсролын газар	1		1		1						Орхон аймаг дахь ТАГ
16	Өвөрхангай аймгийн боловсролын газар	1			1	1						Чадварлаг Аудит ХХК
17	Өмнөговь аймгийн боловсролын газар	1			1	1						Толин этүгэн аудит ХХК
18	Сүхбаатар аймгийн Боловсролын газар	1		1		1						Сүхбаатар аймаг дахь ТАГ



Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

19	Сэлэнгэ аймгийн Боловсролын газар	1		1		1		1		1							Сэлэнгэ аймаг дахь ТАГ
20	Төв аймгийн боловсролын газар	1		1				1									Ихмонгол хөлөг Аудит ХХК
21	Увс аймгийн боловсролын газар	1		1				1									Увс аймаг дахь ТАГ
22	Ховд аймгийн Боловсролын газар	1		1				1									Ховд аймаг дахь ТАГ
23	Хөвсгөл аймгийн боловсролын газар	1		1						1							Хаан соёмбо аудит ХХК
24	Хэнтий аймгийн Боловсролын газар	1		1						1							Платинум прогресс аудит ХХК
25	Нийслэлийн боловсролын газар	1		1				1									Нийслэл дэх ТАГ
26	Багануур дүүргийн боловсрол төв	1		1				1									Нийслэл дэх ТАГ
27	Нийслэлийн Багахангай дүүргийн боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
28	Баянгол дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
29	Баянзүрх дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
30	Налайх дүүргийн боловсролын хэлтэс	1		1				1				1					Нийслэл дэх ТАГ
31	Сонгинохайрхан дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
32	Сүхбаатар дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
33	Хан-Уул дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
34	Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1		1				1									Нийслэл дэх ТАГ
35	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	1							1								Си Пи Ти Эй Аудит ХХК
36	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	1		1										1			Үндэсний аудитын газар
37	Боловсролын зээлийн сан	1		1													Үндэсний аудитын газар
38	Боловсролын үнэлгээний төв	1							1								Ажу мэргэн Аудит ХХК
39	Боловсролын мэдээллийн технологийн төв	1							1								Ниямазон Аудит ХХК
40	Монгол улсын их сургууль	1								1							Сүлд-Аудит ХХК
41	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	1							1								Стандарт дүгнэлт аудит ХХК
41	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг	1							1								Пийк Ом Аудит ХХК

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан уул аймаг дахь Анагаах ухааны сургууль	1		1		1										Дархан-Уул аймаг дахь ТАГ
41	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль	1				1										Баби Тами Аудит ХХК
41	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль	1		1												Говь-Алтай аймаг дахь ТАГ
42	Соёл урлагийн их сургууль	1				1										Уваа уул Аудит ХХК
43	Хөдөө аж ахуйн их сургууль	1				1					1					Азуре хүлүг аудит ХХК
43	ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агроэкологи, бизнесийн сургууль	1		1												Дархан-Уул аймаг дахь ТАГ
44	Монгол улсын боловсролын их сургууль	1				1										Аккурэйт финанс аудит ХХК
45	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	1				1										Солид Юнити Аудит ХХК
45	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	1		1												Дархан-Уул аймаг дахь ТАГ
46	Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль	1				1										Шинэ баланс аудит ХХК
47	Монгол Улсын Консерватор	1				1										Уваа уул Аудит ХХК
48	Нийслэлийн ерөнхий боловсролын монгол тэмүүлэл сургууль	1				1										Гроут финанс аудит ХХК
49	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	1		1									1			Өмнөговь аймаг дахь ТАГ
50	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	1				1										Пийк Ом Аудит ХХК
51	Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын Бэрх сургууль	1		1												Хэнтий аймаг дахь ТАГ
52	Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	1				1										Си Пи Ти Эй Аудит ХХК



Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

53	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль	1						1	1									Ниямазон Аудит ХХК
54	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль	1						1	1									Лайт энд Дипайт Аудит ХХК
55	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	1	1											1				Үндэсний аудитын газар
56	Сурах бичгийн түрээсийн тогтолцоо	1	1											1				Үндэсний аудитын газар
57	Монгол улсын консерваторийн харьяа Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллеж	1						1	1									Хаан соёмбо аудит ХХК
58	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв ТӨАТҮГ	1	1											1				Үндэсний аудитын газар
59	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа политехник коллеж	1	1											1				Үндэсний аудитын газар
	Бүгд	1,807	11	969	827	885	68	2	1	851	-							

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсролын ерөнхий газар ТТЗ	1474	108,011.4	413	33,959.6	1061	74,051.8	1415	107,077.1	59	934.3
2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль	4	159.8			4	159.8	4	159.8		
3	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг	1	6.7			1	6.7	1	6.7		
4	Багануур дүүргийн боловсрол төв	4	159.9	1	0.4	3	159.5	4	159.9		
5	Баянзүрх дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	2	871.4			2	871.4	2	871.4		
6	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	2	4.5			2	4.5	2	4.5		
7	Боловсролын үнэлгээний төв	1	199.7			1	199.7	1	199.7		
8	Булган аймгийн Боловсролын газар	1	0.7			1	0.7	1	0.7		
9	Говь-Алтай аймгийн боловсролын газар	3	1,370.7			3	1,370.7	3	1,370.7		
10	Дорноговь аймгийн боловсролын газар	1	10.4			1	10.4			1	10.4
11	Дорнод аймгийн боловсролын газар	2	418.0	2	418.0			2	418.0		
12	Дундговь аймгийн Боловсролын газар	1	0.2			1	0.2	1	0.2		
13	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	4	28.9			4	28.9	4	28.9		
14	Монгол улсын их сургууль	5	4,166.4			5	4,166.4	5	4,166.4		
15	Монгол Улсын Консерватор	5	1,953.0	3	1,380.4	2	572.6	5	1,953.0		
16	Монгол улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллеж	6	80.2			6	80.2	6	80.2		
17	Налайх дүүргийн боловсролын хэлтэс	1	7.1			1	7.1	1	7.1		
18	Нийслэлийн Багахангай дүүргийн боловсролын хэлтэс	1	5.2			1	5.2	1	5.2		
19	Нийслэлийн боловсролын газар	3	171.4	1	156.4	2	15.0	3	171.4		

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	3	16.3			3	16.3	3	16.3				
21	Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль	1	1.8			1	1.8	1	1.8				
22	Орхон аймгийн боловсролын газар	1	5.7			1	5.7	1	5.7				
23	Соёл урлагийн их сургууль	1	23.6			1	23.6	1	23.6				
24	Сонгинохайрхан дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	3	483.3	2	15.7	1	467.6	3	483.3				
25	Сүхбаатар дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1	157.3			1	157.3	1	157.3				
26	Төв аймгийн боловсролын газар	4	2,238.9	2	1,466.3	2	772.6	3	2,238.9	1	-	1	-
27	Хан-Уул дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	2	372.7			2	372.7	2	372.7				
28	Ховд аймгийн Боловсролын газар	5	575.7			5	575.7	5	575.7				
29	Хөдөө аж ахуйн их сургууль	3	34.7			3	34.7	3	34.7				
30	Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	5	156.4	4	38.1	1	118.3	5	156.4				
31	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	3	205.8			3	205.8	3	205.8				
	Нийт дүн	1553	121,897.7	428	37,434.9	1125	84,462.8	1492	120,953.0	61	944.7	61	944.7

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсролын сайд ТЭЗ	2	328.4	-	-	1	128.4	1	200.0	-	-	-	-
2	Боловсролын ерөнхий газар ТТЗ	2878	367,234.5	637	1,908.1	852	196,638.2	1371	168,353.6	18	334.61	0	-
3	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-
4	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан уул аймаг дахь Анагаах ухааны сургууль	2	27.9	1	0.4	-	-	1	27.5	-	-	-	-
5	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль	1	5.1	-	-	-	-	1	5.1	-	-	-	-
6	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг	5	42.9	-	-	2	41.0	3	1.9	-	-	-	-
7	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	9	1,007.7	5	40.8	2	694.1	2	272.8	-	-	-	-
8	Архангай аймгийн Боловсролын газар	2	17.8	-	-	2	17.8	-	-	-	-	-	-
9	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	3	235.0	-	-	-	-	3	235.0	-	-	-	-
10	Багануур дүүргийн боловсрол төв	2	1.8	-	-	1	1.4	1	0.4	-	-	-	-
11	Баянзүрх дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	3	3.5	2	1.5	-	-	1	2.0	-	-	-	-
12	Баян-Өлгий аймгийн Боловсролын газар	1	7.9	-	-	1	7.9	-	-	-	-	-	-
13	Баянхонгор аймгийн боловсролын газар	1	1.4	1	1.4	-	-	-	-	-	-	-	-
14	Боловсролын зээлийн сан	4	33,736.5	-	-	3	33,641.7	1	94.8	-	-	-	-
15	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	1	27.4	-	-	1	27.4	-	-	-	-	-	-
16	Боловсролын мэдээллийн технологийн төв	1	127.5	1	127.5	-	-	-	-	-	-	-	-
17	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	3	0.7	1	0.5	1	-	1	0.3	-	-	-	-
18	Боловсролын үнэлгээний төв	7	138.2	1	5.9	3	102.7	3	29.6	-	-	-	-

01 ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЖ
ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

19	Боловсролын яам	3	83.5		-	2	23.8	1	59.7			
20	Булган аймгийн Боловсролын газар	2	25.1	1	0.5	1	24.6		-			
21	Говь-Алтай аймгийн боловсролын газар	4	33.5	3	31.3	1	2.3		-			
22	Говьсүмбэр аймгийн Боловсролын газар	5	14.1	2	6.6	2	6.1	1	1.4			
23	Дархан-Уул аймгийн Боловсролын газар	2	9.8		-	2	9.8		-			
24	Дорноговь аймгийн боловсролын газар	1	1.2	1	1.2		-		-			
25	Дорнод аймгийн боловсролын газар	4	142.2		-	2	12.8	2	129.4			
26	Дундговь аймгийн Боловсролын газар	4	10.2	3	5.8	1	4.4		-			
27	Завхан аймгийн Боловсролын газар	6	105.1	3	2.8	3	102.2		-			
28	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв ТӨАТҮГ	3	263.6		-		-	3	263.6			
29	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	2	29.9	1	0.5	1	29.4		-			
30	Монгол улсын боловсролын их сургууль	4	158.5	3	6.7	1	151.8		-			
31	Монгол улсын их сургууль	2	836.9	2	2.7	6	756.5	5	77.7			
32	Монгол Улсын Консерватор	2	412.9		-		-	2	412.9			
33	Монгол улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь хөгжим бүжгийн коллеж	9	19.3	4	14.1		-	5	5.2			
34	Напайх дүүргийн боловсролын хэлтэс	3	26.2		-	1	11.1	2	15.1			
35	Нийслэлийн боловсролын газар	6	164.1		-	1	110.2	5	53.9			
36	Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	5	435.4	2	11.0		-	3	424.4			
37	Нийслэлийн ерөнхий боловсролын монгол тэмүүлэл сургууль	3	4.5		-	1	-	2	4.5			
38	Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль	3	25.4		-	1	20.5	2	4.9			
39	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль	1	21.8		-		-	1	21.8			
40	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль	2	3.5	1	0.9		-	1	2.7			

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41	Орхон аймгийн боловсролын газар	5	15.0	1	1.8	4	13.2		-			
42	Өвөрхангай аймгийн боловсролын газар	2	1.0		-	2	1.0		-			
43	Соёл урлагийн их сургууль	7	114.7		-			7	114.7			
44	Сонгинохайрхан дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	3	7.4	2	1.9		-	1	5.5			
45	Сүхбаатар аймгийн Боловсролын газар	5	38.3	1	15.0	3	23.3	1	-			
46	Сүхбаатар дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1	22.0		-		-	1	22.0			
47	Сэлэнгэ аймгийн Боловсролын газар	4	39.8		-	3	38.3	1	1.5			
48	Төв аймгийн боловсролын газар	3	-		-		-	3	-			
49	Увс аймгийн боловсролын газар	1	3.3		-		-	1	3.3			
50	Хан-Уул дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	1	4.0		-		-	1	4.0			
51	Ховд аймгийн Боловсролын газар	3	53.4	0	-	0	-	3	53.4			
52	Хөвсгөл аймгийн боловсролын газар	3	14.6		-		-	3	14.6			
53	Хөдөө аж ахуйн их сургууль	11	486.0	3	6.8	4	344.7	4	134.5			
54	Хэнтий аймгийн Боловсролын газар	2	14.7	1	5.5	1	9.2		-			
55	Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	2	6.6		-	1	0.7	1	5.9			
56	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	2	179.9	1	1.4		-	1	178.5			
57	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	6	503.8	1	1.7	1	41.6	4	460.5			
58	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа политехник коллеж	4	2,314.7		-	4	2,314.7		-			
	Бүгд	3068	409,590.1	685	2,204.2	918	235,352.8	1458	171,698.5	18	19	334.6
												-

6.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсролын сайд ТЭЗ	14	-			3	-	11	-		
2	Боловсролын ерөнхий газар ТТЗ	1301	80,457.1	10	9.1	231	24,821.3	1049	55,402.5	11	224.2
3	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан уул аймаг дахь Анагаах ухааны сургууль	1	-					1	-		
4	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг	2	260.7			1	260.7	1	-		
5	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	4	-			3	-	1	-		
6	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	1	49.1				-	1	49.1		
7	Багануур дүүргийн боловсрол төв	3	37.6				-	3	37.6		
8	Баянгол дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	4	48.9			1	-	3	48.9		
9	Баянзүрх дүүргийн засаг даргын дэргэдэх боловсролын хэлтэс	2	8.6				-	2	8.6		
10	Боловсролын зээлийн сан	4	167,958.3			4	167,958.3		-		
11	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	2	-				-	2	-		
12	Боловсролын мэдээллийн технологийн төв	1	-				-	1	-		
13	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	2	-				-	2	-		
14	Боловсролын яам	2	-			1	-		-	1	-
15	Говь-Алтай аймгийн боловсролын газар	2	4.9			1	4.9	1	-		
16	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв ТӨАТҮГ	1	-				-	1	-		
17	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	2	45.8			2	45.8		-		
18	Монгол улсын боловсролын их сургууль	2	98.4			1	74.9		-	1	23.5
19	Монгол улсын их сургууль	3	2,693.5			2	2,693.5	1	-		
20	Монгол Улсын Консерватор	1	496.8			1	496.8		-		
21	Налайх дүүргийн боловсролын хэлтэс	2	21.4				-	2	21.4		
22	Нийслэлийн Багахангай дүүргийн боловсролын хэлтэс	2	3.3				-	2	3.3		

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр

Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг